



ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮАА

*Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны үр
дүн*



ҮАГ-НАГ/2014/01-НА

Зуунмод сум.

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

**ҮАГ-ын харьяа Төв аймгийн
Аудитын газар**

Тэргүүлэх

Аудитор: Л.Жаргалсайхан

Аудитор: Ц.Базарсад

2014 оны 05 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал

7027-2287 дугаарын утас,
7027-2582 дугаарын факсаар
харилцана уу.

**Товчилсон үгийн
тайлбар.....**
**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга
зүй.....**

Бүлэг 1

*Сангийн төлөвлөлтийг зохих журмын дагуу хийсэн
байна.*

Бүлэг 2

*Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө зохих
журмын дагуу зарцуулагдсан байна.*

Бүлэг 3

*Сангийн хөрөнгийн зарцуулалтанд хийсэн дотоод
хяналт шалгалт үр дүнтэй явагдсан байна.*

Холбогдох байгууллагын санал:

Нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн санал .

Саналд өгсөн тайлбар

.....

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудитын нэр:

Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны үр дүн

2. Аудитын код:

ҮАГ-НАГ/2014/01-НА

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны санал, Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

Нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн байдлыг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараахь дэд зорилтын дагуу аудит хийнэ.

- Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн төвөлгөөг хууль тогтоомжтой уялдуулан төлөвлөсөн үү?
- Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хуулийн хүрээнд зөв зарцуулж байна уу?
- Сангийн хөрөнгийг зарцуулах бодлого, үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй байна уу?

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад Нийгмийн даатгалын сангийн 2013 оны үйл ажиллагааг хамруулан санхүүжилт, зарцуулалтыг олгох үйл ажиллагааг гүйцэтгэсэн банк тэдгээрийн орон нутаг дах салбар нэгж, холбогдох байгууллага, хувь хүмүүсийг хамруулав.

6. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, Нийгмийн даатгалын хэлтэс, арилжааны банкны олголтын үйл ажиллагааны талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, сангийн хөрөнгийн бүрдэлт, зарцуулалтын баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

7. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараахь хууль эрхийн акт, шалгуур үзүүлэлтийг эх сурвалж болгон ашиглав. Үүнд: Төрийн аудитын тухай хууль, ЗГ-ын тусгай сангийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Банкны тухай хууль, ББС-ийн үйл ажиллагааны тухай хууль, Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой тогтоол, тушаал, заавар, аргачлал журмын эмхтгэл, холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.

8. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг 2014 оны 04-р сарын 20-ноос эхэлж 05 сарын 01 хүртлэх хугацаанд багтаан ахлах аудитор Ц.Базарсад гүйцэтгэж, Аудитын менежер хянан удирдлаа.

9. Үндсэн мэдээлэл:

Төв аймагт Нийгмийн даатгалын хэлтэст нь УНДЕГазраас санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж байна.

Сангийн төлөвлөлтийг зохих журмын дагуу хийсэн байна.

Бүлэг 1

1.1 Сангийн хөрөнгийн төлөвлөгөөг хууль тогтоомжийн дагуу төлөвлөсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуулиуд болон бусад хууль тогтоомжийг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2009 оны 05 дугаар сарын 26-ний өдрийн 19-р тогтоолоор баталсан Нийгмийн даатгалын сангийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах аргачлалын дагуу төлөвлөж хугацаанд нь дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллажээ.

Сангуудын төсвийн төслийг хийхдээ өмнөх 2 жилийн гүйцэтгэл, 2012 оны батлагдсан төсөв, 2012 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг үндэслэн ирэх 3 жилийн төсвийн төсөл, төсөөллийг өөрийн программ хангамж ашиглан хийж гүйцэтгэсэн байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн даргын шийдвэрээр 5 хүний бүрэлдэхүүнтэй багийг томилж тэдгээрийн боловсруулсан төсвийн төслийг хамт олны хурлаар оруулж саналыг тусган ажилласан байна.

Сангуудын төсвийн төслийг боловсруулахдаа Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 19-р тогтоолоор баталсан журамд заасны дагуу нийгмийн даатгалын хамрах үзүүлэлтүүдийн хүрээнд, шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, улсын төсвөөс олгох хөрөнгө, сангуудын зарлагын үзүүлэлт тус бүрээр өмнөх жилүүдийн дундаж үзүүлэлтийг харгалзан үзэж боловсруулсан байна.

НДСангуудын орлогын төсвийг 12084.5 сая төгрөгөөр төлөвлөж дээд шатны байгууллагад хүргүүлснийг 2013 оны төсвийн тухай хууль болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 02 тоот тогтоол, НДЕГазрын даргын 2013 оны 01-р сарын 09-ны өдрийн 1/84 тоот тушаалын дагуу 12600.6 сая төгрөг буюу 516.1 сая төгрөгөөр нэмэгдэж, зарлагыг 26254.1 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлэхэд 29818.3 сая төгрөг буюу 3564.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагдсан байна.

Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөлийн 2009 оны 5-р сарын 26-ны өдрийн 19 тоот тогтоолын 1-р хавсралтад заагдсаны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2012 оны 12-р сарын 03-ны А/363 тоот тушаалаар Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн сарын нормативыг нэгдүгээр хавсралтаар баталж ирүүлсэний дагуу орлогын төлөвлөгөөг барьж ажилласанаар төлөвлөгөө давж биелэсэн байна.

Төлөвлөгөөний давсан орлогоор 2013 оны төсвийг 2013 оны 11-р сарын 25 өдрийн 1/1848 тоот тушаалаар тодотгон баталж ирүүлсэн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага зөрүүтэйгээр батлагдсан нь 2013 оны төсвийн төслийг хийсний дараа буюу 2013 оны эхнээс тус хоёр сангийн шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөн тогтоосонтой холбоотой байна.

Тодотгосон төсвөөр нийт орлого 2013 оны төслөөс 1445.4 сая төгрөгөөр, 2013 оны батлагдсан төсвөөс 929.3 сая төгрөгөөр нэмж батласан нь ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуульд хамрагдсан иргэдийн нөхөн даатгалын төлбөрийн орлого, сайн дурын даатгалд хамрах иргэдийн тоо ихэссэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдсэнтэй холбоотой байна.

1.2 Нийгмийн даатгалын сангийн орлогын эх үүсвэрийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлсэн байна.

Нийгмийн даатгалын тухай хуулинд Нийгмийн даатгалын сангуудын орлогын эх үүсвэрийг

- Даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл
- Ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл
- Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, үнэт цаасны арилжаанаас олсон орлого
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги
- Улсын төсвөөс олгох хөрөнгө
- Бусад эх үүсвэрээс бүрдэхээр хуульчилсан байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2013 онд

Даатгуулагчаас төлсөн шимтгэл -7 199. 9 сая төгрөг

Ажил олгогчоос төлсөн шимтгэл - 6 718. 8 сая төгрөг

Хүүгийн орлогоор -103. 4 сая төгрөг

Төр даатгалыг нь хариуцах иргэдийн ЭМД- 464 .7 сая төгрөг

Алдангийн орлогоор – 21. 6 сая төгрөгийн орлогыг тус тус оруулсан байна.

Даатгуулагчаас төлөгдсөн шимтгэл хураамжийн орлогыг задалвал:

УИХ-аас 2012 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “Ажилласан жил , тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-ийн дагуу

- Нөхөн даатгалын төлбөрөө төлсөн иргэдээс 875. 2 сая төгрөг,
- Сайн дурын даатгуулагчаас- 649. 7 сая төгрөг,
- ЭМД-ын хураамжаар -125. 1 сая төгрөг тус тус оруулсан байна.

Нийгмийн даатгалын тухай хууль болон Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулиудаар сургалт сурталчилгаа хийж, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцох ажлаар аймгийн хүн ам олонтой Борнуур, Батсүмбэр, Эрдэнэсант зэрэг сумдад ажиллаж, сургалт сурталчилгаанд 40000 гаруй хүн хамрагдаж, 37989 иргэний бичиг баримтыг газар дээр нь үзэж зөвлөгөө өгсөнөөр орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.

1.3 Нийгмийн даатгалын мөнгөн хөрөнгийн сангуудын орлогыг зохих журмын дагуу хуваарилсан байна.

2013 онд Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь 13 529.9 сая төгрөгийн шимтгэлийн хураамжийн орлого оруулах төлөвлөгөөтэй ажилласнаас 14 497.6 сая төгрөгийн орлого оруулж нийт төлөвлөгөөг 107.1 хувиар давуулан биелүүлсэн байна. Сангийн орлогыг төрөл тус бүрээр биелүүлэн ажилласан нь сангийн хуваарилалтыг жигд хийсэнтэй холбоотой байна.

Бүх сангуудын орлогыг давуулан биелүүлж ажилласан боловч ажилгүйдлийн даатгалын сан нь 197.8 хувиар давж биелэсэн нь УИХ-ын 2012 оны 10-р сарын 25-ны өдрийн хуралдаанаар нийгмийн даатгалын тэтгэмжийн даатгалын сан болон ажилгүйдлийн даатгалын санд шимтгэл төлөх хувь хэмжээг өөрчлөн баталсантай холбоотой байна.

САНГУУДЫН ОРЛОГЫН ТӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/сая.төг/

Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар
Тэтгэвэр	8611.9	8805.3	102.2
Тэтгэмж	894.6	1014.8	113.4
ҮОМШӨ	804.8	842.4	104.6
ЭМД	3002.3	3407.4	113.5
Ажилгүйдэл	216.4	427.8	197.8
	13529.9	14497.6	107.1

Бүлэг 2

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө зохих журмын дагуу зарцуулагдсан байна.

2.1 Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу зарцуулсан байна.

1. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу дор дурдсан зориулалтаар зарцуулсан байна.

Тэтгэвэр, тэтгэмж олгох

- Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авах болзол хангасан 10581 орчим тэтгэвэр авагчдад 25 821.9 сая төгрөгийн тэтгэврийг олгосон.
- Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх нь үүссэн 1457 даатгуулагчид ХЧТА-ын тэтгэмжинд 106.8 сая төгрөг, 917 даатгуулагчид ЖА-ны тэтгэмжинд 780.7 сая төгрөг, 423 даатгуулагчид 126.9 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийг олгосон байна.
- ҮОМШӨ-ний сангаас тэтгэмж авах эрх нь үүссэн 34 даатгуулагчид ҮОМШӨ-ний ХЧТА-ын 14.5 сая төгрөг, 8 даатгуулагчийн Рашаан сувилалын зардалд-1.3 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.
- Ажилгүйдлийн даатгалын сангаас болзол хангасан 377 даатгуулагчдад 359.6 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг хуулинд заасан хугацаагаар тус тус олгосон байна.

Шалгалтын явцад 6 сумыг сонгон Нийгмийн даатгалын сан тус бүрийн харилцах дансны хуулгыг боловсруулж, Нийгмийн даатгалын хэлтсийн сангийн программтай харилцах данс тус бүрийн орлого зарлагын гүйлгээг тулган шалгахад: Дараах зөрүү илэрлээ

- Алтанбулаг суманд Хаан банкин дээр 0.3 сая төгрөг, Төрийн банкинд 145.3 сая төгрөг,
- Сэргэлэн суманд Төрийн банкинд 27.6 сая төгрөг
- Батсүмбэр Хаан банкинд 7.2 сая төгрөг, Төрийн банкинд 14.2 сая төгрөг
- Баян суманд Хаан банкинд 2.9 сая төгрөг, Төрийн банкинд 2.5 сая төгрөг,
- Зуунмод суманд Хаан банк 19.8 сая төгрөг, Төрийн банкинд 379.1 сая төгрөгийн зөрүү тус тус гарсан нь хадгаламж банк төрийн банк болж үлдэгдэл шилжүүлсэн, андуурсан гүйлгээний залруулга хийсэн, хаан банкны тэтгэврийн дансны улайлтыг гүйлгээнд давхар оруулсанаас гарсан байна.

Нийгмийн даатгалын “байгууллага, үндэсний зөвлөл болон салбар зөвлөлийн” үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд

- Улсын төсвийн санхүүжилттэй 1 эмнэлэг, хувийн хэвшлийн 1 эмнэлэг, рашаан сувилал 2, хөнгөлөлттэй эмээр үйлчлэх 28 эмийн сан нийт 32 эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан 99897 даатгуулагчдад 2 111.6 сая төгрөгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.
- ЭМД-ын сангаас тусламж үйлчилгээний зардлын санхүүжилт авахаар хүрэлцэн ирсэн даатгуулагчдын материалаас болзол, шаардлага хангаагүй нийт 66.3 сая төгрөгийг ЭМД-ын албаны хяналтаар хасч санхүүжүүлсэн байна

Хууль тогтоомжид заасан бусад төлбөр, зардлыг санхүүжүүлэхэд

2. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол “нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн гүйлгээ гараагүй байна.

3. “Хуримтлалын сангийн хөрөнгийг” Засгийн газрын бонд болон Монгол банкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах замаар нэмэгдүүлж болно” гэж тус тус заасан байдаг. Үүний дагуу хийгдсэн гүйлгээ байгаа эсэхийг шалгах боломжгүй байна.

4. Хуримтлалын сангаас Засгийн газрын бонд, Монгол банкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгаж, Улсын Их Хурал батална гэж заасны дагуу сангийн төсөвт тусгагдаж баталсан хөрөнгө байхгүй байна.

5. Хуримтлалын сангаас арилжааны банкинд байршуулах хөрөнгийн хэмжээг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хамтран тогтооно гэж заасны дагуу байршуулсан байдлыг шалгахад Хуримтлалын сангийн хөрөнгөнөөс хийгдсэн гүйлгээ гараагүй байна.

2.2 Нийгмийн даатгалын хөрөнгийг сан хооронд шилжүүлээгүй, зориулалтын бус гүйлгээ хийгдээгүй байна.

2013 онд Төв аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5-д заасны дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл болох 5.3 сая төгрөгийг ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд шилжүүлсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Нийгмийн даатгалын хэлтсийн дотоодын хяналт шалгалт, Мэргэжлийн хяналтын газрын Нийгмийн халамжийн байцаагч нарын хийсэн шалгалтаар хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, ашигласан зөрчил илэрээгүй байна.

2.3 Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хувьд тухайн оны шимтгэл, хураамжийн орлогоор зарлагыг нөхдөггүй, НДЕГ-аас татаас санхүүжилт авч тэтгэвэр, тэтгэмжээ олгон ажилладаг учир хуримтлалын сангийн хөрөнгийг Засгийн Газрын бонд болон Монгол банкнаас гаргасан үнэт цаас худалдан авах, арилжааны банкинд байршуулах замаар нэмэгдүүлэх боломжгүй байна.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 12-т Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө болон тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нөөцөлсөн хөрөнгийг **Хуримтлалын сан** гэж заасан байна.

Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хувьд тухайн оны шимтгэл, хураамжийн орлогоор тухайн оныхоо сангуудын зарлагыг нөхдөггүй бөгөөд НДЕГ-аас татаас санхүүжилт авч тэтгэвэр, тэтгэмжээ олгон ажилладаг.

2013 онд тус хэлтэс нь НДЕГ-аас тэтгэврийн даатгалын санд 16 832.9 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын санд 122.4 сая төгрөгийн санхүүжилтыг тус тус хүлээн авсан бол, тэтгэврийн даатгалын сангаас 200.0 сая төгрөг, ҮОМШӨ-ий даатгалын сангаас 662.9 сая төгрөг, ЭМД-ын сангаас 740.0 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 60.0 сая төгрөгийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлсэн байна.

2013 онд Төрийн болон Хаан банктай хамтран ажиллахаар байгуулсан 13/02 тоот гэрээнд заасны дагуу сангуудын харилцах дансны өдөр тутмын чөлөөт үлдэгдэлд жилийн 5.5 хувийн хүүг хуримтлуулан тооцож, сарын эцэст хүүгийн орлогыг харилцахад төвлөрүүлсэнээр 103.4 сая төгрөгийн хүүгийн орлогыг бүртгэлд тусгасан байна.

Бүлэг 3

Сангийн хөрөнгийн зарцуулалтанд хийсэн дотоод хяналт шалгалт үр дүнтэй явагдсан байна.

3.1 Сангийн хөрөнгийн зарцуулалтанд хийсэн дотоод хяналт шалгалт үр дүнтэй явагдсан байна.

Хөндлөнгийн хяналтаар Аймгийн МХГазрын шалгалт 2012 онд ҮОМШӨ-ний санд, 2013 онд Тэтгэврийн санд шалгалт хийгдсэн бөгөөд ямар нэгэн шаардлага хангаагүй болон болзол хангаагүй материалаар олгосон тэтгэвэр тэтгэмжийн зөрчил илэрээгүй байна

Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод хяналтар үйл ажиллагаа, иргэд даатгуулагчид үзүүлж байгаа ажил үйлчилгээ нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд шалгалт хийх 14 төрлийн төлөвлөгөө гарган гүйцэтгэлийг тооцон ажилласан байна. Үүнд

- **Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааний талаар:**

Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалтын байдалд хэсэгчилсэн буюу ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагчдад ажилгүйдлийн тэтгэмж олгуулахаар бодож ирүүлсэн 185 тэтгэмжийн нэхэмжилсэн дүнгээс нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн хуульд заасан нөхцөл болзлыг хангаагүй болон тэтгэмж бодолтын алдаанаас үүдэлтэй 9.0 сая төгрөгийг зөрүүг илрүүлэн хасч, дутуу олгосон 8.8 сая төгрөгийг нэмж сангийн зардлыг хянан баталгаажуулж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Хяналтаар сумдын байцаагч нарын тэтгэмж бодолтонд дараахь нийтлэг зөрчлүүд гарсан байна. Үүнд:

1. Ажилгүйдлийн санд шимтгэл төлсөн хугацааг буруу тооцох
2. Буруу тооцсоноос тэтгэмжийг буруу хувиар бодсон
3. Тэтгэмж бодох сүүлийн 3 сарын цалинг буруу авсан
4. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75%-иас бага цалингаар тэтгэмж бодсон
5. Ажлаас халагдсан үндэслэлийг буруу хэрэглэж тэтгэмж олгох хоногийг буруу тооцсон зэрэг зөрчлүүд гарсан байна.

Мөн Эрүүл сэндийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар 125 сайн дурын даатгуулагчдын хувийн хэргийг үзэн шалгахад дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Даатгуулагчаар гарын үсэг зуруулаагүй
- Гэрээг нөхөн бичсэн
- Мөнгө төлсөн баримт байхгүй
- Гэрээний хугацаа дууссан, цуцлагдсан гэрээг архивлаагүй
- Байцаагчийн гарын үсэг тамга байхгүй
- Гэрээ дуусах хугацаа тодорхойгүй
- Бичилтгүй хоосон гэрээ хавсрагдсан
- Нөхөн даатгал хийсэн зэрэг нийтлэг алдаанууд давтагдаж байгааг анхааруулж байцаагч нарт заавар зөвлөгөө өгч ажилласан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого хариуцсан байцаагч нарын тайлан авалт, үлдэгдэлийн баталгаажилт, тайлангийн үндэслэлд хяналт хийсэн талаар:

Шимтгэл орлогын байцаагчийн ажил олгогчдоос ирүүлсэн НД-7,8 тайлангуудыг мэдээллийн сантай тулган шалгахад мэдээллийн санд 85 ажил олгогчийн нийгмийн даатгалийн тайланг хүлээн авч мэдээлэлд оруулахаас тайлан ирүүлсэн 68 ажил олгогчийн тайлан авалт, үлдэгдлийн, баталгаажилт, тайлангийн үндэслэл зэргийг мэдээллийн сантай тулган шалгахад үлдэгдэл зөрүүтэй 11 ажил олгогч, Нийгмийн даатгалын шимтгэлийн

тайлан НД-7-г гаргаагүй 3 ажил олгогч байсан зэрэг зөрчлүүдийг илэрүүлж дараа улирлын тайлангаар бүрэн арилгаж ажилласан байна.

3.2 Өмнөх аудитаар тогтоосон акт, өгсөн зөвлөмж хэрэгжүүлж ажилласан байна.

2012 оны Санхүүгийн тайлангийн аудитаар дараах 2 зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлсэн ажилласан байна.

- Нийгмийн даатгалын сангуудын шимтгэлийн орлогыг сангуудад тогтсон хувь хэмжээгээр жигд хуваарилах
- Нийгмийн даатгалын сангуудыг сан хооронд гүйлгэн зарцуулахгүй байх гэсэн зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд 6 зөвлөмж өгсөн байна.

- Байгууллагын удирдлагын зүгээс өдөр тутмын орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавьж ажиллах
- Сумдын байцаагч нарын хариуцлагыг сайжруулж сан хоорондын андуурч, ташаарсан гүйлгээ гаргахгүй байх талаар анхаарч ажиллах
- Төвлөрсөн дансны сан хоорондын зөрүүнээс үүссэн авлагын гүйлгээнүүдийн залруулгыг хийж авлага, өглөгийг барагдуулах.
- Эрүүл хүүхэд аяны хөтөлбөрийн хэрэгжилтийн аймгийн хэмжээний судалгааг гаргуулан эргэх холбоог бий болгон үр өгөөжийг тооцож ажиллах
- Барилгыг худалдаж орлогыг санд төвлөрүүлэх
- Цаашид шимтгэлийн өрөнд хөрөнгө, бараа, материал авахгүй байхад анхаарч ажиллах

ДҮГНЭЛТ

1. Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2013 онд 5 төрлийн сангийн орлогыг жигд биелүүлэн ажилласан байна.
2. Сан хооронд гүйлгэн зарцуулсан зардал байхгүй бөгөөд сумдаас хийх төвлөрүүлэлт сан андуурч хийсэн гүйлгээг залруулсан, ташаарсан орлогын залруулгын гүйлгээнүүд сум бүрт нийтлэг гарсаар байна.
3. Сангийн хөрөнгийн зарцуулалтанд хийсэн дотоод хяналт шалгалт үр дүнтэй явагдсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Ч.Болормаад:

1. Сангийн хуваарилалт, зарцуулалт, төвлөрүүлэлтэнд анхаарч сан андуурч ташаарсан гүйлгээ хийхгүй байх.
2. Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийх байхгүй
3. Ажил олгогч нарын шимтгэлийн тооцоог улирал бүр өссөн дүнгээр тооцоо нийлсэн актаар баталгаажуулж хэвшүүлэх.
4. Аж ахуйн нэгж байгууллагуудын шимтгэлийн өр авлагын мэдээ, судалгааг ирүүлж хамтран ажиллах.
5. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлүүдийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

ТАЙЛАН БИЧСЭН: АУДИТОР

Ц.БАЗАРСАД

